

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, "ТОП ГАН ДРИЛЛИНГ" ХХК
 НАРЫН ХӨСӨРӨНД БАЙГУУЛСАН "БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ
 АШИГЛАХ, ҮЙЦДЭЭР БАЙГУУЛАХАЙ ХӨНӨГДСӨН ДЭД БҮГЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ,
 ДАМЖИХ БАЯН НӨМӨР ДҮҮГЭХ ТУХАЙ ГЭРЭЭ" -НИЙ 2024 ОНЫ 2024/103
 ДУГААР ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2025 оны 02 дугаар сарын 01

Баянхонгор аймаг

№	Гэрээний тусгай нөхцөл	Хэрэгжилт	Үнэлгээ /Хувиар/
1	2	3	4
1	3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бус эсхүл үндэслэлгүй эсхүл шаардлага бус байдлаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж Компанид нааштайгаар шийдвэрлүүлэх;	Гэрээний хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ямар нэгэн нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан зүйлс гараагүй ба талууд гэрээнд хүлээсэн үүргээ биелүүлж ажиллалаа.	100%
2	3.1.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр Хөдөлмөр халамж үйлчилгээний газраар дамжуулан эсвэл олон нийтийн хэрэгсэл болон цахимаар нийтэд зарлах	Баянхонгор аймгийн Галуут суманд байрлах уурхайн оффис дээрээ ажилд орох сонирхолтой хүмүүсийн анкетыг хүлээн авч, сонгон шалгаруулж Баянхонгор аймгийн иргэдийг ажлын байраар ханган ажиллаж байна.	100%
3	3.1.3. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах	Шаардлагатай ажлын байранд ажилд орж байгаа сум орон нутгийн иргэдийг Улаанбаатар хотод болон онлайн хэлбэрээр ажлын байрны болон аюулгүй ажиллагааны сургалтуудад хамруулдаг. Мөн ажлын байран дээрээ очсоны дараа Сургагч багш нар тухайн мэргэжлийн ажлын байрны сургалтуудыг баталсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.	100%
4	3.1.4. Ажиллах хүчнийхээ 50-иас доошгүй хувийг орон нутгаас ажиллуулах, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэдээллийн санд	Ажлын байранд тэнцсэн иргэдийг тогтмол ажлын байраар ханган ажилласан.	70%

1	2	3	4
5	<p>бүртгэлтэй иргэдээс ажилд авах</p> <p>3.1.5. Хөршөөлдөг байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх</p>	<p>Уурхайн үйл ажиллагааны талаар сум болон багын иргэдийн нийтийн хурал болон өөрсдийн цахим хаягаар доорх мэдээллүүдийг тогтмол танилцуулж ажиллалаа.</p> <p>Уурхайн үйл ажиллагаа (Нээлттэй ажлын байр, байгаль орчны бодлого)</p>	100%
6	<p>3.1.6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг биелүүлж ажиллах</p>	<p>2024 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт гэдэтгэлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан. БОННУ-нд тулгуурлан төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг хамгийн бага түвшинд бууруулах, болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-аар хянан, батлуулж мөрдлөг болгон ажиллаж байна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сум орон нутаг, харьяалагдах Байгаль орчны газар, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны төлөөлүүдээс бүрдсэн ажлын хэсэгт амжилттай дүгнүүлсээр ирсэн. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийсэн ажлуудыг доор товч дурдвал.</p> <p>Усан орчин</p> <ol style="list-style-type: none"> 2024 онд "Монгол-Ус" ТӨҮГ-аар ус ашиглах дүгнэлт гаргуулсан Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулсан. <p>Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг</p> <ol style="list-style-type: none"> Уурхай дотор зорчих замуудын явах чиглэлийг заасан тэмдэглэгээ, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбаруудыг нэмэлтээр байрлуулсан. <p>Уурхайд ашиглагдаж буй ШТМ-ийг хадгалахдаа хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгийг бохирдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж</p>	100%

1	2	3	4
7	3.1.7 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэх;	тусгай цэгт хадгалдаг. 2024 онд 5.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 2.03 га талбайд биологийн нөхөн сэргээлт, тусгай зөвшөөрлийн талбайгаас 8 км зайд 5.0 га талбайд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд техникийн нөхөн сэргээлтийн ажил тус тус хийсэн.	100%
8	3.1.8 Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт тохиож, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг тусалцаа үзүүлэх;	Уурхайн хүрээнд бүх барилга байгууламж болоод үйл ажиллагааг хамруулан Гамшгийн эрсдэлийн үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий мөргөлийн байгууллагаар хийлгэн тус үнэлгээний дагуу Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан, ажиллах баг болоод тоног төхөөрөмжийн бэлэн байдалд ажиллаж байна.	100%
9	3.1.9 Гурвал талууд бүгд зөвшөөрсөн тохиолдолд зөхион байгуулалтад орсон бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гурвалсан гэрээний үндсэн дээр талбай олгох, хамтран ажиллах; /Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батласан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 4.3 дэх заалт/	2024 онд ямар нэг бичил уурхай болон нөхөрлөлтэй хамтран ажиллаагүй.	100%
10	3.1.10. Эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах	Манай компани нь 2024 онд эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлсэн.	100%
11	3.1.11. Уул уурхайн ил тод байдлыг бий болгож, олборлосон баялаг, татвар төлбөрөө тайлагнаж байх;	Олборлосон металлыг баталгаажсан лабораториор баталгаажуулж Баянхонгор аймаг дахь арилжааны банканд (Голомт банкны салбар) тушаасан.	100%
12	3.1.12. Олборлосон металлыг Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лабораториор баталгаажуулж, Монгол банк болон эрх бүхий арилжааны банканд тушааж байх	Олборлосон металлыг баталгаажсан лабораториор баталгаажуулж Баянхонгор аймаг дахь арилжааны банканд (Голомт банкны салбар) тушаасан.	100%
13	3.1.13. Уурхай эрхлэхэд шаардагдах Ашигт малтмалын тухай хуулийн 35.3-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг бүрэн хангасан тохиолдолд ажлаа эхэлж байх;	2024 онд Уулын ажлын төлөвлөгөө, БОМТ-өө болон бусад шаардлагатай бичиг баримтуудыг бүрэн ханган ажилсан.	100%
14	3.1.14. Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд аймаг,	Аймаг, сумын тулгамдсан асуудал бүрд байнга дэмжиж нягт	

1	2	3	4
15	<p>сумын өмнө тулгандаж буйгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санал санаачилга гаргах;</p> <p>3.1.15.Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаднаас буюу бусад зах зээлээс авахгүй байх, орон нутгийн тухайлсан ААН-тэй гэрээ байгуулах;</p>	<p>уялдаатай ажилдаг.</p> <p>Тул газрын дүрээнд уурхайн компанийн хэрэгцээний ихэнх хувь буюу хүнсний бараа бүтээгдэхүүн, барилгын материал, өдөр тутмын хэрэглээ, нүүрс, хот хоорондын тээвэр, харуул хамгаалалт зэрэг үйлчилгээ худалдан авалтууд дээр орон нутгийн байгууллага болон хувь хүмүүсийн өмнөн ажиллаж байна. Уурхайн хэрэгцээнд шаардлагатай бараа бүтээгдэхүүн болгоод үйлчилгээ нь манай компанийн зүгээс таних шаардлага болгоод Монгол улсын хэмжээнд дагаж мөрдөж буй хууль тогтоомж, стандартад нийцэж буй тохиолдолд орон нутгийн зах зээлээс боломжит бүх төрлийн худалдан авалт болгоод хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийн ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтыг, 2. Барилгын материалын худалдан авалтыг, 3. Нүүрсний худалдан авалтыг. 4. Бохир соруулах үйлчилгээг. 5. Орон нутгийн малчдаас мах, сүү цагаан эдээ. 6. Сэлбэг тоног төхөөрөмж 	<p>100%</p> <p>100%</p>
16	<p>3.1.15.1.Мах, сүү, хүнсний ногоог 100% тухайн орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан худалдан авах;</p>	<p>Хүнсний бүтээгдэхүүн болон бараа бүтээгдэхүүн тоног төхөөрөмж сэлбэгийн худалдан авалтыг Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг “Цагаан ээж” “Тод Авто Сэлбэг” “Баялаг Орд” “Цэлмэг Өглөө” “Хас Авто Сервис” ХХК-иас хийдэг бөгөөд 2024 онд 230 сая гаруй төгрөгийн худалдан авалт хийсэн.</p> <p>Мөн бусад жижиглэнгийн худалдан авалтын Баянхонгор аймгийн ААН, хувь хүмүүсээс хийдэг. Үүнээс гадна орон нутгийн малчдаас уурхайн хэрэглээний махаа зах зээлийн ханшаар худалдан авдаг бөгөөд 2024 онд нийт 56 сая төгрөгөөр худалдан авсан байна.</p>	<p>100%</p>
17	<p>3.1.15.2.Ажлын хувцас, дээжний уутыг тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан худалдан авах;</p>	<p>Баянхонгор аймгийн ААН, хувь хүмүүсээс хийдэг.</p>	<p>100%</p>

1	2	3	4
18	3.1.15.3.Харуул хамгаалалтыг сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгох;	Гэрээт харуул хамгаалалтын "Геомандал секьюрити"ХХК-ай хамтран ажилдаг.	70%
19	3.1.16.Аж ахуйн үйл ажиллагааны ашгаас авах татвараас бусад татвар шимтгэлүүдийг орон нутгийн төсөвт төлдөг байх;	Улаанбаатар хотод төлдөг	70%
20	3.1.17.Ус ашигласны төлбөрийг тоолуураар хуулийн хугацаанд нь толно. Хэрвээ усны тоолуур суурилуулаагүй бол Эрх бүхий байгууллагаас багалсан дүгнэлтийг үндэслэн Бөснцагаан-Орог нуурын сав газрын захиргаатай ноогдуулалтын гэрээ хийж, төлбөрийг орон нутагт тушаана. Ус ашигласны төлбөрийг дүгнэлтээр төлөх гохиолдолд 50-иас доошгүй хувийг ажил эхлэхэд Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна;	Ус ашигласны төлбөрийг ус ашиглах дүгнэлтийн дагуу төлсөн бөгөөд 2024 онд нийт 98,585,303.04 төгрөгийн төлбөр төлсөн.	100%
21	3.1.18.Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх;	2024 онд "Монгол-Ус" ТӨҮГ-аар ус ашиглах дүгнэлт гаргуулсан.	100%
Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь:			94,28%

ХЯНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

ДҮГНЭСЭН
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРҮҮДАЛТ, БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЭНХБАЯР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
"ТОП ГАН ДРИЛЛИНГ" ХХК-ИЙН ҮҮРХАЙН
ДАРГА

П.ГАН-ЭРДЭНЭ